

СҮМБЭР СУМЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ БАРАГДУУЛАЛТЫН ТАЙЛАН

2022.06.20

Сүмбэр

2022 оны эхний хагас жилийнбайдлаар Сумын Засаг дарга түүний Тамгын газарт нийт-117өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сумын Засаг дарга түүний Тамгын газартхандаж ирүүлсэн өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг тухай бүр өгч ажиллалаа.

Ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, хүүхэд үрчлэх, тухай-5
- Буцалтгүй тусламж, эмчилгээний зардал хүссэн- 6
- Тусгай зөвшөөрөл-9
- Худаг усны асуудлаар-6
- Газрын асуудлаар-52
- Отрын асуудлаар-3
- Модны урамшуулалд хамрагдах-2
- Архинаас гаргах сайн дурын эмчилгээнд хамрагдах-15
- Сумхөгжүүлэх сангаас авсан зээлээ хойшлуулах-3
- Бусад-15

Сумын Засаг дарга болон газрын даамалд газар эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлт гаргасан 52 өргөдөлөөс 28 өргөдөлийг сумын Газар зохион байгуулалтын хурлаар хэлэлцэн, 6 болон 12 сард сумын ИТХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэн хариу хүргүүлэн, 13 өргөдөл, хүсэлтийг тухай бүр хариуг өгч, газар сунгах, гэрээ гэрчилгээ гаргуулах, маргаантай асуудал шийдвэрлүүлэх 11 өргөдөл шийдвэрлэх шатандаа,хуулийн хугацаандаа байна.

“Гэр бүлийн тухай хууль”-ийн дагуу эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон 4 иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон сумын Засаг даргын захирамж гарган, хүүхэд үрчлэх 1 хүсэлтийг хамтарсан багийн хурлаар шийдвэрлэсэн ба тусламж, тэтгэмж хүссэн иргэдийн өргөдөлийг тухай бүр

шийдвэрлэн 5.450.000төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн. Тамхины тусгай зөвшөөрөл хүссэн 5 иргэний 2 өргөдөлийг цахимаар авч шийдвэрлэсэн.

Бусад өргөдөл гомдол нь байрны урд талын муу усны нүх хальж урссан, морины зүчээрүү угаадас асгаад байна, Дрифтийн тэмцээн зохион байгуулах, Аяганы хонхорын гүний худгийг хариуцан ажиллаж байгаа хүлээлгэн өгөх хүсэлтэй, төрийн албан хаагчийн эмчилгээ, тусламжтай холбоотой3, Баянбулагийн эгнээнд нохой дайрсан, малжуулах төсөлд хамруулаагүй шалтгааныг тодруулах 2, 1-р багийг цэвэр усны сүлжээнд холбох хөрөнгийг шийдвэрлэж өгөх, хот дотор такси үйлчилгээ явуулах тул хамтран ажиллана уу, АА бүлгийн цуглаан хийх байрны асуудлыг шийдвэрлэж өгнө үү, гэрийн усны хаялага, шуудууг засварлаж өгнө үү зэрэг 15 өргөдөл, гомдол, хүсэлт байна

Нийт 117 өргөдлийн 14 өргөдөл шийдвэрлэх шатанд хуулийн хугацаанд, 102 өргөдлийг бүрэн шийдвэрлэж 88 %-ийн гүйцэтгэлтэй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.САРНАЙ

ХЯНАСАН:

ЗТДГ-ЫН ДАРГА

П.НАРАНМАНДАХ

СҮМБЭР СУМЫН 2022ОНЫ1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ БАРАГДУУЛАЛТЫН ТАЙЛАН

2022.03.23Сүмбэр

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Сумын Засаг дарга түүний Тамгын газарт нийт-28 өргөдөл, гомдол санал хүсэлт ирсэн.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сумын Засаг дарга түүний Тамгын газартхандаж ирүүлсэн өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг тухай бүр өгч ажиллалаа.

Ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай-4
- Буцалтгүй тусламж, эмчилгээний зардал хүссэн- 2
- Худаг усны асуудлаар-2
- Газрын асуудлаар-11
- Отрын асуудлаар-1
- Бусад-8

Сумын Засаг дарга болон газрын даамалд газар эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлт гаргасан 2 өргөдлийг ИТХ-аар хэлэлцүүлж хариу хүргүүлэн, газар сунгах, гэрээ гэрчилгээ гаргуулах, маргаантай асуудал шийдвэрлүүлэх 9 өргөдөл шийдвэрлэх шатандаа,хуулийн хугацаандаа байна.

“Гэр бүлийн тухай хууль”-ийн дагуу эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон 4 иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон сумын Засаг даргын захирамж гарган шийдвэрлэсэн ба тусламж, тэтгэмж хүссэн иргэдийн өргөдөлшийдвэрлэх шатанд байна.

Нийт 28 өргөдлийн 11 өргөдөл шийдвэрлэх шатанд, 17 өргөдлийг бүрэн шийдвэрлэж 60,7%-ийн гүйцэтгэлтэй байна.

Тайлан бичсэн:Дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн

Э.Сарнай

Хянасан. ЗТДГ-ын дарга:

П.Наранмандах